**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 06 өдөр Дугаар А/181 Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйл, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалтыг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын 3.2.14 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг хавсралт ёсоор батлсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах, багш нарт зориулсан сургалт зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд тус тус даалгасугай.

3. "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчныг бүрдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургууль бүрт гамшиг, онцгой байдлын үеийн дасгал сургуулилт хийх кабинет байгуулах зардлыг судлан, 2019 оны төсөвт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Х.Галсанхүүд даалгасугай.

4. Суралцагчдыг гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт сургах "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тэдний сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлаар бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран үр дүнтэй зохион байгуулахыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэнд даалгасугай.

САЙД Ц.ЦОГЗОЛМАА

0900561

Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын Сайдын 2018 оны 04 дугаар сарын 06 ны өдрийн А/181 дугаар тушаалын хавсралт

## “АЮУЛГҮЙ АМЬДРАХ УХААН “ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлттэй холбоотойгоор аюулт үзэгдлийн давтамж дэлхий нийтээр улам ихсэх төлөвтэй байна. Энэ нь улс орон, байгууллага олон нийтэд гамшгийг даван туулах чадавхаа нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байгаа юм. Монгол оронд ган, зуд, аадар бороо, мөндөр, хүчтэй цасан болон шороон шуурга, үер зэрэг байгаль, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн давтамж, эрч хүч нэмэгдэж, улмаар хүн амын осол, эндэгдэл мэдэгдэхүйц өсөн, нийгэм, эдийн засагт учруулах хор хохирлын хэмжээ сүүлийн 20 гаруй жилд 2 дахин нэмэгджээ[1]. Мөн хүний үйл ажиллагаатай холбоотой осол, обьектын болон ой хээрийн түймэр, мал амьтны гаралтай халдварт өвчний тархалт нэмэгдэж байна.

СӨБ, ЕБС-ийн суралцагчид нь өдрийн ихэнх цагийг цэцэрлэг, сургууль дээр өнгөрөөдөг, аливаа гамшгийн үед нэмэлт тусламж шаардлагатай эмзэг бүлэг болох тул цэцэрлэг, сургуулийн аюулгүй байдлыг хангах, гамшгийг даван туулах чадавхийг нэмэгдүүлэх боловсрол эзэмшүүлэх нь нэн чухал асуудал юм. Энэ утгаараа дэлхий нийтэд цэцэрлэг, сургуулийн аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой ач холбогдол өгч байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хүрээнд сургуулийн аюулгүй байдлыг хангах, аюулгүй байдлын боловсрол эзэмшүүлэх асуудал 2007-2008 оноос үндэс суурь тавигдан, 2010 онд “нэг сая аюулгүй сургууль” санаачлага болон өргөжиж, 2012 оноос “аюулгүй сургууль” үзэл баримтлал хөгжиж ирсэн. Энэ санал санаачлага, үзэл баримтлал нь дэлхий дахины гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж буй "2015-2030 онд гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт тусгалаа олж хэрэгжиж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015- 2030 онд хэрэгжүүлэх “Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийн “Гамшгийн эрсдэлийг ойлгох” тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг хамарсан гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг албан болон албан бус боловсрол, бүх түвшний иргэний боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтанд тусгах ажлыг дэмжих"[2] гэж тодорхойлсон. Уг баримт бичгийг батлалцсаны хувьд Монгол улс нь албан ба албан бус боловсролоор дамжуулж гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй"[3] гэж тунхагласан.

---

[1] Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, 2011
[2] Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015- 2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг, 2015
[3] Монгол Улсын үндсэн хууль, 1992

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийн "Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн хүрээн дэх 4.7 дахь зорилтод "2030 он гэхэд бүх суралцагчид тогтвортой хөгжлийн болон тогтвортой амьдралын зан үйл, хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайванч болон хүчирхийллийн бус соёл, дэлхийн иргэншил болон соёлын олон янз байдал, тогтвортой хөгжилд "соёлын оруулах хувь нэмэр зэрэг тогтвортой хөгжлийг түргэсгэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшсэн байх нөхцлийг хангах"[4] гэж заажээ.

Монгол Улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 13.3.6-д "оюутан, суралцагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн шатны боловсролын байгууллага зохион байгуулна"[5] гэж заасан.

"Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль"-ийн 5.12.7, 12.8-д багшийн эрх үүрэгт хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргах тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагчтай заавал зөвшилцөх тухай, мөн "Бага дунд боловсролын тухай хууль"-ийн 4.1.8-д бага боловсролын агуулгад "зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох, 5.1.5-д суурь боловсролын агуулгад "хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох", 6.1.4-т бүрэн дунд боловсролын агуулгад "бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх" гэж аюулгүй байдлын асуудлыг тусгасан байна[6].

"Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого"-ын 2.1, 2.2 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор баталсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн 3.2.10-т "Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухааны боловсрол, хүмүүжил олгох хичээлийг сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах, сургалтыг хүүхдийн насны онцлогт тохируулан явуулах"[7] гэж, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын 3.2.14-т "Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургана"[8] гэж тус тус заасан.

## ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

### 2.1. Сургуулийн өмнөх боловсрол

Бага насны хүүхэд нь багш, эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр аюул ослын тухай төсөөлөлтэй болж, аюулгүй амьдралын дадал хэвшил, өөрийгөө хамгаалах аргад суралцан, бусдаас тусламж хүсэж, бусдад тусалдаг чадвартай болно.

### 2.2. Бага боловсрол

Суралцагч нь тохиолдож болзошгүй аюул ослын төсөөлөлтэй болж, урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, шийдвэр гаргах чадвар эзэмшиж, оновчтой үйл хөдлөл хийж чаддаг болно.

---

[4] НҮБ, Ерөнхий Ассамблейн баталсан тогтоол 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр, 2015
[5] Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
[6] Бага дунд боловсролын тухай хууль, 2002
[7] Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, 2015
[8] Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2016

### 2.3. Суурь боловсрол

Суралцагч нь болзошгүй аюулт үзэгдэл, ослыг төсөөлж, аюулгүй байдлын бэлтгэлтэй байх, өөрийгөө хамгаалах, бусдад туслах, анхны тусламж үзүүлэх, аюулгүй зөв сонголт бүхий үйл хөдлөл хийж чаддаг болно.

### 2.4. Бүрэн дунд боловсрол

Суралцагч нь болзошгүй аюулт үзэгдэл, ослыг төсөөлж, хариу арга хэмжээ авах, анхны тусламж үзүүлэх, сайн дурын үйл ажиллагаанд оролцох, дасан зохицож амьдрах чадвартай, амьдралын зөв дадал хэвшлийг эрхэмлэдэг иргэн болно.

## ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

### 3.1. Сургуулийн өмнөх боловсрол

***ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ***

***Ахуйн орчны аюулгүй байдал***

1. Ахуйн осол, гэмтэл
   а. Хайч, харандаа, шугам зэрэг үзүүртэй зүйл амандаа хийхгүй байх, зөв барих, дамжуулах, зөөхдөө болгоомжтой байх, бариад гүйхгүй байх дадалтай болох
   б. Шил, шаазан эдлэл хагардаг, хагарсан зүйлс барих, гишгэхээс болгоомжлох сэрээ, савх, хайч, хутга бариад гүйхгүй байх, зөв барьж хэвших
   в. Зай, жижиг шүр, амны цаас, товчийг чих, хамар, амандаа хийхгүй байх
   г. Шатаар буух, булан тойроходоо огцом хурдтай гүйхгүй, анхаарлаа өөр зүйлд сарниулахгүй, ярихгүй, бие биеэ түлхэхгүй байх дэгийг баримтлах
   д. Гал тогооны өрөөнд юу байгааг нэрлэх, яаж хэрэглэдэг талаар ойлголттой болох, ойртож болохгүй аюултай зүйлсийг таних
   е. Түлэгдэх халуун тогоо, халуун хоол, цай, ус, гал зэргээс хол байх, том савтай нөөцөлсөн ус, бохир усны цооног, нойл зэрэгт унах аюултайг мэдэх, ойртохгүй байж хэвших
2. Эм, ахуйн хэрэглээний бодис, түүний хэрэглээ
   а. Насанд хүрэгчдийн зааваргүй эм уухгүй, дур мэдэн хэрэглэхгүй байхыг анхаарах
   б. Үнэртэй ус, агааржуулагч цацлага, газ, гэр ахуйн угаалга, цэвэрлэгээний бодис аюултайг мэдэх
3. Анхны тусламж
   а. Яаралтай тусламжийн цүнхэнд байгаа зүйлсийг нэрлэх, зориулалтыг мэдэх

***Нийгмийн орчны аюулгүй байдал***

4. Гэр, цэцэрлэг, амьдарч буй орчны аюулгүй байдал
   а. Цэцэрлэгийн гадаад, дотоод орчинтой танилцах, аюулгүй тоглох дэг дүрмийг нэрлэх, дагаж мөрдөх, танил орчин, юмсын байршлын хялбар зургийг хараад ярих, зурж дүрслэх
   б. Орох, гарах хаалганы шат, довжооноос хальтирахаас сэргийлэх таних тэмдгийг ялган таних
   в. Төөрсөн үед бусдаас тусламж хүсэх
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдал
   а. Замын зарим тэмдэг, тэмдэглэгээг таних, нэрлэх, ангидаа болон гадаа талбайд дөрвөн замын уулзварын хөдөлгөөний дүрмийг мэдэх, баримтлах

б. Насанд хүрэгчдийн хамт явган хүний гарц, гэрлэн дохиогоор гарах, хөдөлгөөнд оролцохдоо баруун гарын дүрэм баримтлахыг мэдэх

в. Автомашинаар зорчихдоо зориулалтын суудалд суух, бүс зүүх, арын байрлалд сууж хөдөлгөөнд оролцох, автомашины цонхоор толгой, бие, гараа гаргахгүй байхыг мэдэх, хэвших

г. Автомашины зам, зогсоол, гарц, гүүр, гарам дээр тоглох аюултайг мэдэх

6. Мэдээллийн технологийн аюулгүй байдал

   а. Гар утас, компьютер удаан тоглохгүй байхыг мэдэх

   б. Зурагт хязгаартай үзэх хугацааг мөрдөх

7. Агаар, ус, хөрсний бохирдол

   а. Хог хаяхгүй байх, хог хаягдлаа зориулалтын саванд ялгаж хийж хэвших

   б. Гол, усанд хог хийхгүй байхыг мэдэх

   в. Агаарын бохирдол ихтэй орчинд амны хаалт хийж хэвших

8. Уур амьсгалын өөрчлөлт

   а. Цаас, усыг гамтай хэрэглэж хэвших

***ГАМШИГ, ОСОЛ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ***

***Байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл***

9. Газар хөдлөлт

   а. Газар хөдлөлтийн чичиргээг мэдрэх, хүчтэй чичиргээ тавилга, эд юмс хөдөлж унах, нурах, хагарах аюултай, цахилгаан шат ашиглаж болохгүйг ойлгох (унах нурах аюултай тавилга эд юмсыг заах, зурагт тэмдэглэх, бэхлэх аргыг мэдэх)

   б. Газар хөдлөх үед өөрийгөө хамгаалах СУУ, НУУГД, ХҮЛЭЭ гэсэн дүрмийг мэдэх, сургуулилт хийх (тухайлбал ширээн доогуур орох, ширээний хөлнөөс сайн барих, амьтны үйл хөдлөлийг дуурайж суух, тэвчээртэй хүлээх гэх мэт)

   в. Гамшиг тохиолдсон үед хэрэглэх нөөцөлсөн хүнс, эд зүйлсийг мэдэх, сонгох, нөөцлөхийг ойлгох

   г. Хөл гараа зүсэх, хатгахаас болгоомжлох, өөрийгөө хаана байгааг хүмүүст хэлэх, өөрийн сэтгэл хөдлөлөө хүмүүст хэлэх, тайвшрах аргад суралцах

   д. Насанд хүрэгчдийн зааврын дагуу аюулгүй газарт очихдоо ГҮЙХГҮЙ, ТҮЛХЭХГҮЙ, ЯРИХГҮЙ, ЭРГЭЖ БУЦАХГҮЙ гэсэн дүрмийг баримтлан сургуулилт хийх, хэвших

10. Үер усны осол, хөрсний нуралт, гулсалт, аянга

   а. Цэвэр ус, түлээ, дулаан хувцас, дуртай тоглоомоо үерийн усанд автахгүй газар хадгалахыг мэдэх, нөөцлөх, усыг гамтай хэрэглэх

   б. Харгалзах хүнгүй гол, тогтоол усанд орохгүй байх, голын өндөр эргээс хол байхыг мэдэх

   в. Үерийн үед өндөрлөг газар насанд хүрсэн хүмүүсийн зааврaар очих дадлага хийх

   г. Дуу цахилгаантай аадар бороо орсон үед гэрээсээ гарахгүй байх, шаардлагатай үед дүрвэж гарах, гар утас болон цахилгаан хэрэгслийг ашиглахгүй байхыг мэдэх

11. Ган, зуд

   а. Хэт нартай үед сүүдрэвчинд тоглох, гадаа гарахгүй байх, гарахдаа малгай өмсөх, шингэн зүйл уухыг мэдэх, хэвших

б. Толгой, бие наранд халах, нарших, түлэгдэхээс сэргийлэх

12. Хүчтэй цасан болон шороон шуурга

а. Цаг агаарын мэдээнээс цас, бороо, салхи шуургыг нэрлэх, ялган таних, тэмдэглэх

б. Хүчтэй цасан болон шороон шуурганаар гадаа явахад зам талбай, барилга байшин харагдахгүй байх, агаарт элдэв тоосонцор тархдаг болохыг мэдэх

в. Цаг агаарт тохируулан хувцаслах малгай, бээлий, ороолт зүүхийг ойлгох

***Хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл***

13. Гал түймэр (ой, хээр, объектын)

а. Индүү, халуун тогоо, цахилгаан зуух, цахилгаан халаагуур, сэнс, цахилгааны залгуур, уртасгагч, разетка, гэрийн зуух, газ, газаар ажилладаг бүхий л хэрэгсэл аюултай талаар ойлголттой болох, ойртохгүй байх, хуруу гараа хийж оролдож үзэхгүй, хэрэглэхгүй байх дадалтай болох

б. Шүдэнз, лаа, асаагуур асаах, гал түлэх үйлдэл хийх, тоглож болохгүйг ойлгох

в. Гал гарсан үед бусдаас тусламж хүсэх, 101,102,105 утасны дугаарыг мэдэх, эцэг эх, ойр дотны хүмүүс рүү залгаж мэдэгдэх, цэцэрлэгийн болон гэрийн хаягаа мэдэх, хэлэх

г. Гарцын тэмдэг тэмдэглэгээг таних, гал утаа гарвал гарцын тэмдэг дагаж гадагш гарахыг мэдэх

д. Гал, утаа гарсан үед аль болох гүйхгүй, биенээ түлхэхгүй, зааврыг сайн сонсохын тулд хоорондоо ярихгүй, буцаж орохгүй байхыг мэдэх, гал гарсан өрөөнөөс хурдан гарах, аюулгүй газар луу зугатаж тэндээ хүлээх сургуулилт хийх

е. Утаанаас хамгаалж ам, хамраа алчуураар дарах, утаатай орчинд доогуур явахыг мэдэх, дадлага хийж тоглох

14. Хүн, мал, амьтны халдварт өвчин

а. Гадаа тоглож орж ирээд гараа угааж, хоолойгоо зайлж хэвших

б. Бусдын амнаас чихэр, жимс авч идэхгүй байх дадалтай болох

в. Мал, амьтны ам, хамарт хүрэхгүй байхыг мэдэх

г. Бусдын халбага, сойз, гар нүүрийн алчуур, хөтөвчийг дамжуулахгүй байхыг ойлгох

**3.2. Бага боловсрол**

***ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ***

***Ахуйн орчны аюулгүй байдал***

1. Ахуйн осол, гэмтэл

а. Хурц ирмэгтэй, үзүүртэй хичээлийн болон ахуйн багаж, хэрэгслийг (хайч, гортиг, шугам, хутга, халуун тогоо, цахилгааны утас, индүү, плитка, зуух, халуун ус, уур гэх мэт) зориулалт, аюулгүй ажиллагааны заавар дагуу хэрэглэж хэвших

б. Ахуйн хэрэглээний зүйлсийн нэр, зориулалт, заавар, шошго уншиж ойлгох

в. Аюул, ослын талаар ойр дотны хүмүүс болон орон нутаг дахь яаралтай тусламжийн утасны дугаар (101, 102, 103, 107)-аас зөвийг сонгон, аюул осол, гэрийн хаяг, байршлыг үнэн зөв мэдээлэл өгөх, тусламж хүсэх

2. Эм, ахуйн хэрэглээний бодис, түүний хэрэглээ

   а. Эм, ахуйн хэрэглээний бодисын нэр, зориулалт, заавар, тэмдэг тэмдэглэгээг уншиж ойлгох

   б. Эмийн зөв зохистой хэрэглээ, буруу хэрэглэснээс гарах үр дагаврыг ойлгох

3. Анхны тусламж

   а. Яаралтай тусламжийн цүнх, үүргэвч, зориулалтыг мэдэх, бэлтгэх, тайлбарлах

   б. Ахуйн хүрээний бэртэл, гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн талаар мэддэг байх (шалбарах, эсгэх, түлэгдэх гэх мэт)

***Нийгмийн орчны аюулгүй байдал***

4. Гэр, сургууль, хүрээлэн буй орчин дахь аюулгүй байдал

   а. Анги хамт олон, сургуулийн дэг, дүрэм, журмыг мөрдөх, түүнийг мөрдөөгүйгээс гарах үр дагаврыг ойлгох

   б. Сургууль, гэрийн байршлыг мэдэх, бусдад тайлбарлах, багшийн удирдамж, зааврын дагуу сургууль гэрийн орчин, онцлог байгууламж болон сургууль гэрийн хоорондох аюулгүй замын зураглал гаргах, тэмдэглэгээ хийх (план зураг, маршрут, аюултай орчин, байгууламж тусгах гэх мэт), аюулгүй байдлыг ханган явах

   в. Гэр, сургууль болон олон хүнтэй газар тохиолдож болох аюул, ослыг мэдэх, үл таних хүн, бусдын нөлөөнд автахгүй байх (үе тэнгийнхний болон бусад хүмүүсийн дарамт шахалт гэх мэт), татгалзаж сурах

   г. Төөрсөн үед орчны талаарх онцлог зүйлсийг ажиглах, зүг чигээ баримжаалах (нар, од, өвс ургамал, онцлох барилга, байшин гэх мэт), бусдаас тусламж хүсэх

5. Замын хөдөлгөөний аюулгүй байдал

   а. Замын тэмдэг, тэмдэглэгээг ялган таних, бусдад тайлбарлах

   б. Замын хөдөлгөөнд оролцох үед явган зорчигчийн үүргийг мэдэх, анхаарал болгоомжтой оролцох

   в. Ердийн хөсөг, тээврийн хэрэгслээр зорчих үед биеэ зөв авч явахыг эрхэмлэх (хамгаалах бүс, хамгаалалтын нэмэгдэл хэрэгсэл хэрэглэх, хог хаяхгүй, гар толгой гаргахгүй, бариулаас барих гэх мэт)

6. Мэдээллийн технологийн аюулгүй байдал

   а. Гар утас, компьютер, зурагт зэрэг мэдээллийн технологийн хэрэгслийг зөв зохистой хэрэглэх

   б. Цахим орчны эерэг, сөрөг нөлөөллийн талаар эргэцүүлэх, шаардлагатай тохиолдолд өөртөө болон бусдад эрсдэлгүй байдлаар хэрэглэх

7. Агаар, ус, хөрсний бохирдол

   а. Зориулалтын бус газарт хог хаяхгүй, орчныг бохирдуулахгүй байх, хог хаягдлыг зориулалтын саванд ялган хийж хэвших

   б. Агаарын бохирдол ихтэй орчинд (тоосжилт, утаа гэх мэт) амны хаалт хэрэглэж хэвших

8. Уур амьсгалын өөрчлөлт

   а. Уур амьсгалын өөрчлөлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг зарим хүчин зүйлсийг мэдэх, түүнийг бууруулахад өөрийн хувь нэмрийг оруулах (цахилгаан хэмнэх, усаа хэмнэх, цаасаа гамтай хэрэглэх, мод тарихын ач холбогдлыг мэдэх, арчлах, хамгаалах, хоол хүнсээ зөв сонгон хэрэглэх гэх мэт)

***ГАМШИГ, ОСОЛ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ***

***Байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл***

9. Газар хөдлөлт

   а. Газар хөдлөлтийг төсөөлөх, авах арга хэмжээний тухай ойлголттой болох (дуут дохио, юмс унаж, хагарч, нурж, гулсаж ирэхгүй газар, бэлтгэх эд зүйлс, нөөцлөх хоол хүнс гэх мэт)

   б. Гамшгийн үеийн зарлан мэдээллийн дохио дуугарсан үед насанд хүрэгчдийн заавар, дүрмийн дагуу ажиллах

   в. Гамшгийн дараа аюулгүй байдлаа хангах аргаас мэдэх (хөл гараа зүсэх, бэртэж гэмтэхээс болгоомжлох, өөрийгөө хаана байгааг хүмүүст хэлэх дуу чимээ гаргах, сэтгэл санаагаа тайван байлгах гэх мэт)

10. Ган, зуд, үер, аянга, хүчтэй цасан болон шороон шуурга

   а. Ган, зуд, үер, аянга, хүчтэй цасан болон шороон шуурга, тэдгээрийн үр дагаврын тухай ойлголттой болох

   б. Цаг агаарын мэдээ тогтмол сонсож хүнд үзүүлэх нөлөөллийг ойлгох, тохирох үйлдэл хийх (наранд халах, нарших, түлэгдэх, хөлдөх, төөрөхөөс сэргийлэх гэх мэт)

***Хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл***

11. Гал түймэр (ой, хээр, объектын)

   а. Гал түймрийн тухай ойлголттой болох, гал түймэр гарах эх үүсвэр, шалтгаан, үр дагавар, хор уршгийг ойлгох

   б. Сургууль, гэр, орон сууц дахь гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тэмдэг, тэмдэглэгээ, аврах гарцын зураглал ойлгох, ялган таних, гал түймрийн үед орон байрнаас аюулгүй гарах, бусдад мэдээлэх аргад суралцах

12. Хүн, мал, амьтны халдварт өвчин

   а. Мал, зэрлэг болон гэрийн тэжээмэл амьтан, ургамал, шавьжнаас учирч болох аюулыг мэдэх, халдварт өвчнөөс сэргийлэх, хувийн ариун цэврийг сахих

   б. Түгээмэл тохиолдох халдварт өвчний тухай ойлголттой болох (ханиад, гэдэсний халдварт өвчин гэх мэт), хамгаалах энгийн аргад сурах, эрүүл ахуйн дэглэм сахих (гар угаах, хоолойгоо зайлах гэх мэт)

**3.3. Суурь боловсрол**

***ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ***

***Ахуйн орчны аюулгүй байдал***

1. Ахуйн осол, гэмтэл

а. Бэртэж гэмтэх (унах, хальтрах, дарагдах)-ээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах

2. Эм, ахуйн хэрэглээний химийн бодис, түүний хэрэглээ

   а. Ахуйн хэрэглээний эд зүйлийн сав баглаа боодол дээрх зааврыг ашиглан зөв хэрэглэж хэвших

   б. Ахуйд түгээмэл хэрэглэгддэг химийн бодисыг таних, хортой, хоргүйгээр ялгах, тэдгээрийг зүй зохистой хэрэглэх

   в. Химийн бодис хадгалсан саванд хүнсний бүтээгдэхүүнийг хадгалахгүй болохыг ойлгох

   г. Эмийг эмчийн заавраар хэрэглэж хэвших

3. Анхны тусламж

   а. Гарын доорх материал, багаж хэрэгсэл ашиглан анхны тусламж үзүүлэх

      - Яс хугарах, цус алдах үед үзүүлэх анхны тусламж
      - Үе мултрах, шөрмөс сунах үед үзүүлэх анхны тусламж
      - Түлэгдсэн үед үзүүлэх анхны тусламж
      - Хөлдөлтийн үед үзүүлэх анхны тусламж
      - Дарагдсан хам шинжийн үед үзүүлэх анхны тусламж

***Нийгмийн орчны аюулгүй байдал***

4. Гэр, сургууль, хүрээлэн буй орчин дахь аюулгүй байдал

   а. Туршилт хичээлийн үед аюулгүй байдлыг хангах

   б. Хүрээлэн буй орчны болон орон нутгийн аюулгүй байдлын зураглал гаргах

   в. Хичээлээс гадуурх үйл ажиллагааны үеийн аюулгүй байдлыг төлөвлөх

   г. Сургуулийн орчинд бага насны суралцагчид болон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад туслах

   д. Болзошгүй халдлага, хүчирхийллээс өөрийгөө хамгаалах аргад суралцах, бусдаас тусламж хүсэх

5. Замын хөдөлгөөний аюулгүй байдал

   а. Цаг агаарын өөрчлөлтөөс болж үүсэх зам тээврийн хөдөлгөөний аюулын талаар мэдэх

   б. Өөрийгөө хамгаалахын тулд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг мэдэх

   в. Явган алхах үед болон ердийн хөсөг, унадаг дугуйгаар аюулгүй зорчихыг эрхэмлэх

   г. Бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчихдоо зорчигчийн дүрэм, журмыг баримтлах

6. Мэдээллийн технологийн аюулгүй байдал

   а. Цахим орчинд хувийн мэдээллээ дэлгэхгүй байх, интернетэд бусдын мэдээлэл, зургийг зөвшөөрөлгүй түгээхийн сөрөг нөлөөг ойлгох

   б. Мэдээллийн технологийн хэрэглээ, түүнийг үр бүтээлтэй ашиглахын чухлыг ойлгох (гар утас, интернет)

   в. Цахим харилцааны ёс зүйг эрхэмлэх

7. Агаар, ус, хөрсний бохирдол

а. Хүний үйл ажиллагааны хүрээлэн буй орчин (ус, агаар, хөрс)-д үзүүлж буй нөлөөллийг тайлбарлах (хүн амын хэт төвлөрөл, малын тоо толгой ихсэх гэх мэт)

б. Агаарын бохирдлыг бууруулахад иргэн бүрийн үүрэг оролцоог хэлэлцэх

в. Орон нутгийн цэвэр усны нөөцийг мэдэх, усны чанарыг тодорхойлох

г. Хөрсний бохирдлоос сэргийлэхэд өөрийн оруулах хувь нэмрийг тодорхойлох, хэрэгжүүлэх

8. Уур амьсгалын өөрчлөлт

а. Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй хүний буруутай үйл ажиллагааг тодорхойлох

б. Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн үр дагаврыг хэлэлцэх

в. Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлийг сааруулахад өөрийн оруулах хувь нэмрийг тодорхойлох

***ГАМШИГ, ОСОЛ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ***

***Байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл***

9. Газар хөдлөлт

а. Орон нутаг, улс орон болон дэлхийн хэмжээнд тохиолдож байсан гамшгийн талаар мэдээлэл цуглуулах, танилцуулах

б. Газар хөдлөлтийн улмаас үүсэх орчны (гэр, сургууль орчмын болон гудамж талбайн) эрсдэлийг тооцож, гэмтэж бэртэхээс хамгаалах аргын талаар бодож тунгаах

в. Газар хөдлөлт тохиолдох үед цугларах, цэгцрэх, эгнээ нэмэх, хасах зэргээр өөрийгөө хамгаалах болон бусдад саад учруулахгүй байх, туслах талаар эргэцүүлэх

г. Гамшгийн үеийн зарлан мэдээлэх, сэрэмжүүлэх дохиогоор ажиллаж, газар хөдлөлтийн үе дэх аюулгүй үйл хөдлөлийн дадлага сургуулилалт хийх

д. Гамшгийн дараа өөрийгөө хамгаалах, нүүлгэн шилжүүлэх дүрэм журмыг мэдэх, гэр бүл, найз нөхдөдөө туслах талаар хэлэлцэх

10. Үер усны осол, хөрсний нуралт, гулсалт, аянга

а. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээнд дүн шинжилгээ хийх

б. Үер, усны аюул үүсэх шалтгааныг мэдэх, орон нутгийнхаа эрсдэл бүхий газрыг тодорхойлох

в. Үер болон гол, усны осолд өртсөн тохиолдолд өөрийгөө хамгаалах /дүрвэж холдох, усанд сэлж сурах/

г. Усанд живсэн үед зүрх, уушгийг сэхээн амьдруулах (CPR) анхны тусламж үзүүлэх

д. Аянга үүсэх нөхцөл, учруулах хор уршгийг ойлгож, аянга цахилгааны үед яаралтай авах арга хэмжээг мэдэх

11. Ган, зуд

а. Орон нутаг, улс орны хэмжээнд тохиолдож байсан ган, зудын сургамжийн талаар мэдээлэл цуглуулах, танилцуулах

б. Цаг агаарын байдлыг тэнгэрийн байдал, ургамал, мал, амьтанд ажиглагдах шинж тэмдгээр нь шинжиж амьдрал ахуйдаа хэрэглэж заншиx

в. Эрс хүйтэн, хэт халууны үед өөрийн аюулгүй байдал, амь насаа хамгаалах түр хоргодох байрыг загварчлах

г. Газар тариалан, хоол хүнсний хүрэлцээ хангамж, цөлжилтөд гангийн үзүүлж буй нөлөөг хэлэлцэх

д. Ган, зудын үед гэнэтийн цочролд орж, сэтгэл санааны хямралд орохоос сэргийлж, сэтгэл зүйн бэлтгэлтэй байх

е. Өөрийн орон нутагтаа хувь нэмэр оруулах сайн үйлсийн үйл ажиллагаа явуулах

12. Хүчтэй цасан болон шороон шуурга

а. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг сонсох, бусдад дамжуулах, анхааруулах

б. Хүчтэй салхи, цасан болон шороон шуурганы үед яаралтай авах арга хэмжээг төлөвлөх

в. Төөрсөн үед зүг чигийг тодорхойлох, бусдаас тусламж хүсэх аргыг мэдэх

***Хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл***

13. Гал түймэр (ой, хээр, объектын)

а. Ахуйн шатамхай, тэсрэмтгий бодис бүхий эд зүйлийг тодорхойлох, хялбар шатдаг тэсэрдэг шинжийг ямар тэмдэг, тэмдэглэгээгээр илэрхийлдгийг ялган тайлбарлах

б. Гал түймрийн ангилал, обьектийн түймрээс урьдчилан сэргийлэх, гэр, сургуулийн орчинд гал гарсан үед ажиллах төлөвлөгөө гаргах, түүний дагуу дадлага сургуулилалт хийх

в. Гал түймэр гарахад нөлөөлдөг хүчин зүйлийг мэдэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх, бусдын аюулгүй байдалд санаа тавих

г. Гал унтраагуурын төрөл, зориулалтыг мэдэж, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглаж сурах

14. Хүн, мал, амьтны халдварт өвчин

а. Халдварт өвчний төрөл, үүсгэгч, дамжих замыг ойлгох

б. Мал, амьтнаас хүнд халдварлах халдварт өвчнөөс сэргийлэх, түүний агуулагч, дамжуулагч болдог амьтдын төрөл, зүйлийг мэдэх (сэжигтэй тохиолдолд ойртохгүй байх, мэргэжлийн байгууллагад хандах, мал амьтны гаралтай түүхий эд, хүнсийг боловсруулж хэрэглэх)

в. Ариутгал, халдваргүйжүүлэлт, дархлаажуулалтын ач тусыг ойлгох

**3.4. Бүрэн дунд боловсрол**

***ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ***

***Ахуйн орчны аюулгүй байдал***

1. Ахуйн осол, гэмтэл

а. Нийтлэг тохиолддог ахуйн осол, гэмтлийг хэлэлцэх, дүгнэлт гаргах, өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх

б. Ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгсэл, хийн төлөвт оршдог бодисыг зөв хэрэглэх, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлах

2. Эм, ахуйн хэрэглээний химийн бодис, түүний хэрэглээ

a. Аюултай химийн бодис (тэсрэмтгий, шатамхай, исэлдүүлэгч, идэмхий шинж чанартай) -ыг ялган таних

б. Химийн осол, бохирдолтын хор нөлөө, түүнээс хамгаалах арга замыг нэрлэх

в. Ахуйн хэрэглээний эд зүйлийн сав баглаа боодол дээрх зааврыг ашиглан, зөв хэрэглэж хэвших

г. Эм, химийн бодисын зохистой хэрэглээг бусдад таниулах

3. Анхны тусламж

a. Гарын доорх материал, багаж хэрэгсэл ашиглан анхны тусламж үзүүлэх

- Эм, химийн бодисын хордлогын үед үзүүлэх анхны тусламж
- Цахилгаан гүйдэлд цохиулах үед үзүүлэх анхны тусламж
- Зүрх, уушгийг сэхээн амьдруулах (CPR) анхны тусламж

***Нийгмийн орчны аюулгүй байдал***

1. Гэр, сургууль, хүрээлэн буй орчин дахь аюулгүй байдал

a. Сургуулийн орчинд эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх саналыг дэвшүүлэх

б. Гэмт халдлага хүчирхийлэлтэй холбогдох тохиолдлын талаарх мэдээллийг судлах, хэлэлцэх

в. Хүчирхийлэл гардаг газар, орчныг тодорхойлж зайлсхийх

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдал

a. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг мөрдөх, иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг мэдэх

б. Замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ (мэдээлэх, хориглох, заах, анхааруулах, дараалал тогтоох)-г ялган таних, найз нөхөд, дүү нартаа тайлбарлах

в. Жолоочийн үүрэг, хариуцлагыг ойлгох, зам, тээврийн осолд хариуцлага, хохирлыг барагдуулах шаардлага гардгийг мэдэх

5. Мэдээллийн технологийн аюулгүй байдал

a. Мэдээллийн технологийн сөрөг нөлөөлөл, соёлтой хэрэглээний талаар эргэцүүлэх

б. Нийгмийн сүлжээг аюулгүй, зохистой ашиглах, тохиргоо хийх аргыг мэдэх

в. Цахим хэрэглээний сөрөг нөлөөнөөс болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөлөөлөлд автахгүй байх, өөрийгөө хамгаалах

6. Агаар, ус, хөрсний бохирдол

a. Гол мөрний бохирдол, түүний шалтгаан, үр дагаврыг дүгнэж, усны чанарыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах

б. Орон нутгийн хөрсний шинж чанарыг тодорхойлох, хөрсийг доройтохоос хамгаалж буй аргуудыг бүс нутгаар харьцуулан судлах, өөрийн орны онцлогт тохирсон аргыг тодорхойлох

в. Агаарын бохирдлын өнөөгийн байдал, шалтгааныг тайлбарлаж, бууруулах арга замыг иргэд, олон нийтэд ухуулан сурталчлах

7. Уур амьсгалын өөрчлөлт

a. Уур амьсгалын өөрчлөлт байгалийн гамшгийн давтамжид нөлөөлж буй талаар хэлэлцэх

б. Уур амьсгалын өөрчлөлтөөс нийгэм, эдийн засагт нөлөөлөх томоохон өөрчлөлт, эрсдэлийг тодорхойлох

в. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдлийн талаар хэлэлцэх

***ГАМШИГ, ОСОЛ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ***

***Байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл***

8. Газар хөдлөлт

а. Өрхийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан бэлэн байдлын төлөвлөгөө хийх

б Гамшгийн дараах сэргээн босгох, хөгжүүлэхэд чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг төлөвлөх

в. Гамшгийн үеийн зарлан мэдээлэх, сэрэмжүүлэх дохиогоор ажиллаж, газар хөдлөлтийн үе дэх аюулгүй үйл хөдлөлийн дадлага сургуулилалт хийх

9. Үер усны осол, хөрсний нуралт, гулсалт, аянга

а. Өөрийн орон нутагт байдаг гол мөрөн, нуурын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, орон нутгийн үерийн эрсдэлийн зураг гаргах

б. Үерийн дараах хөрсний нуралт, гулсалтаас урьдчилан сэргийлэх

в. Үерийн дараах хог хаягдлыг зайлуулахад оролцох, эрүүл ахуйн дэглэм баримтлах

г. Аянга цахилгаантай борооны үүлийг таних, аянга ниргэх эрсдэлтэй газрыг тодорхойлох

10. Ган, зуд

а. Ган зудын эрсдэлийг бууруулахын тулд малчдын анхаарах ёстой зүйлсийг мэдэх, малчдад туслах аян өрнүүлэх

15. Хүчтэй цасан болон шороон шуурга

а. Өөрийн амьдарч буй орон нутгийн гамшгаас хамгаалах байгууллагын үйл ажиллагаатай танилцах, тэнд ажиллаж буй хүмүүсийн яриаг сонсох

***Хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл***

11. Гал түймэр (ой, хээр, объектын)

а. Гал түймрийн ангилал, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бусдад мэдээлэх

б. Гэр, сургуулийн галын аюулын зураглалыг ойлгож, хэрэглэх

в. Өөрийн амьдарч буй орон нутгийн гал унтраах байгууллагын үйл ажиллагаатай танилцах

г. Гал унтраагуурын төрөл, зориулалтыг мэдэж, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглах

12. Хүн, мал, амьтны халдварт өвчин

а. Мал, амьтнаас хүнд халдварлах халдварт өвчний үед илрэх шинж тэмдэг, сэргийлэх арга замыг мэдэх

б. Нян, вирусын гаралтай халдварт өвчний үед илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замыг мэдэх

в. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний ач холбогдол, иргэний гүйцэтгэх үүргийг мэдэх

## ДӨРӨВ. АРГА ЗҮЙ

### 4.1. Арга зүйн зарчим, үйл ажиллагаа, хөгжүүлэх чадвар

4.1.1. Сурган хүмүүжүүлэх уламжлалыг орчин үеийн сургалтын аргуудтай хослуулан дараах сургалтын зарчмуудыг баримтална. Үүнд:

- Асуудлыг олж харах, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх
- Хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаатай уялдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх
- Суралцагч төвтэй, оролцоонд тулгуурласан арга зүйг төлөвлөх
- Өгөгдөл, мэдээлэлтэй ажиллах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах гэх мэт сурах үйл ажиллагааг дэмжсэн байх
- Хамтын ажиллагаанд суурилсан байх

4.1.2. Үйл ажиллагаа

Сургалтыг танхимын ба танхимын бус хэлбэрээр хичээл хоорондын интеграцыг ханган зохион байгуулахын зэрэгцээ дараах үйл ажиллагаануудыг сургуулийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлнэ (Хүснэгт 1, 2, 3).

- Орон нутгийн мэргэжлийн ба төрийн бус байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцах
- Мэргэжлийн байгууллага, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурлан дадлага, сургуулилалт хийх
- Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Төсөлт ажил, судалгаа хийх
- Дадлага, сургуулилалт хийх
- Аялал экскурс хийх
- Тайлан бичих, хамгаалах
- Бүтээлч санал санаачлага бүхий сайн үйлсийн аян өрнүүлэх

4.1.3. Сургалт, үйл ажиллагаагаар 21 дүгээр зууны суралцагчийн эзэмшвэл зохих цогц чадамж, чадваруудыг хөгжүүлэхэд анхаарна. Үүнд:

А. Бүтээлч сэтгэлгээний:
- Бүтээлчээр сэтгэх чадвар
- Хувиараа бизнес эрхлэх чадвар
- Зохион бүтээх чадвар
- Эргэцүүлэх чадвар
- Тунгаан бодох ойлгох
- Асуудал шийдвэрлэх чадвар
- Шийдвэр гаргах чадвар

Б. Нийгэмшил, сэтгэл хөдлөлийн:
- Харилцааны чадвар
- Зохион байгуулах чадвар
- Багаар ажиллах чадвар
- Хамтарч ажиллах чадвар
- Нийтэч байх чадвар
- Өөрийгөө бусдын оронд тавьдаг байх, бусдыг өрөвдөх чадвар

В. Хувь хүний хөгжлийн:
- Хувийн сахилга баттай байх чадвар
- Сэтгэл хөдлөлөө хянах, хүлээцтэй байх чадвар
- Хариуцлагатай байх чадвар
- Ёс зүйтэй байх чадвар
- Бие даан суралцах чадвар

- Дасан зохицох чадвар
- Шаргуу байх чадвар
- Хувийн сэдэл тэмүүлэлтэй, өөрийгөө хүндэтгэх чадвар

Г. Дэлхийн иргэний:

- Нээлттэй байх чадвар
- Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах чадвар
- Олон талт соёлыг ойлгох чадвар
- Зөрчилдөөнийг шийдвэрлэх чадвар
- Чөлөөт оролцоотойгоор шийдвэр гаргах чадвар
- Үндэсний онцлог, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах

Д.Мэдээллийн технологийн хэрэглээний:

- Мэдээлэл харилцааны технологиор дамжуулан мэдээлэл олж авах чадвар
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар
- Мэдээллийн технологийг ёс зүйтэй хэрэглэх чадвар

**4.2. Орчин, хэрэглэгдэхүүн**

4.2.1. Сургалтын орчин

Сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг хангасан байна. Тухайлбал:

- Сургууль, цэцэрлэгийн байр зүйн болон аврах гарцын зураглал гаргасан байна.
- Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох хүрз, хувин, элс, шатдаггүй бүтээлэг, гал унтраагуур, утаанаас хамгаалах зориулалтын алчуур бэлтгэсэн байх
- Анги бүрт эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгсэл болон гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангах цүнх бэлтгэсэн байх

4.2.2. Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага

- Эрүүл ахуйн шаардлага хангасан байх
- Ашиглахад энгийн хялбар бүтэц зохиомжтой байх
- Эдийн засгийн хэмнэлттэй байх
- Байгаль орчинд ээлтэй байх
- Мэдээлэл технологийн ололт, амжилтыг хэрэглэхүйц байх

4.2.3. Нийтлэг хэрэглэгдэхүүн

- Сургалтыг зохион байгуулахдаа орон нутаг, сургууль, цэцэрлэгийн нөөц боломжид тулгуурлан дараах хэрэглэгдэхүүнээс сонгон хэрэглэж болно. Үүнд:
  - Аудио, видео материал
  - Төрөл бүрийн зураг
  - Газрын зураг
  - Ном, гарын авлага
  - Интернет
  - Багаж хэрэгсэл
  - Загвар, модель
  - Танин мэдэхүйн болон судалгааны мэдээлэл, баримт материал

**ТАВ. ҮНЭЛГЭЭ**

5.1. Үнэлгээний зорилт, шалгуур

Суралцагчийн сурах үйл ажиллагааны явцад ажиглалт хийж, мэдлэг, чадвар, хандлагад гарч байгаа ахиц, өөрчлөлтийг болон сургалтын үр дүнг дараах үнэлгээний зорилт, шалгуураар үнэлнэ.

<table>
<tr><th rowspan="2">Боловсролын түвшин</th><th colspan="3">Үнэлгээний зорилт, шалгуур</th></tr>
<tr><th>Мэдлэг, ойлголт</th><th>Чадвар</th><th>Хандлага</th></tr>
<tr><td>СӨБ</td><td>Аюул ослын талаарх төсөөлөл<br>Өөрийгөө хамгаалах, бусдыг мэдэрч ойлгох, тусламж хүсэх тухай мэдлэг</td><td>Осол, аюулт үзэгдлээс өөрийгөө хамгаалах</td><td rowspan="4">Осол, аюулт үзэгдлийн өмнө, үед, дараа оновчтой үйл хөдлөл хийх<br>• Санаачлага<br>• Оролцоо<br>• Нөлөөлөл</td></tr>
<tr><td>Бага боловсрол</td><td>Тохиолдож болзошгүй осол, аюулт үзэгдлийн тухай ойлголт<br><br>Өөрийгөө хамгаалах, бусдад туслах аргын тухай мэдлэг</td><td>Осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, шийдвэр гаргах</td></tr>
<tr><td>Суурь боловсрол</td><td>Болзошгүй аюулт үзэгдэл, ослын мэдлэг, ойлголт<br><br>Өөрийгөө болон бусдыг хамгаалах, аргын тухай мэдлэг</td><td>Болзошгүй аюулт үзэгдэл, ослын үед бэлтгэлтэй байх, өөрийгөө хамгаалах бусдад туслах, анхны тусламж үзүүлэх</td></tr>
<tr><td>Бүрэн дунд боловсрол</td><td>Болзошгүй аюулт үзэгдэл, ослын мэдлэг, ойлголт<br><br>Өөрийгөө болон бусдыг хамгаалах, бусдад туслах аргын тухай мэдлэг</td><td>Болзошгүй аюулт үзэгдэл, ослын үед хариу арга хэмжээ авах, анхны тусламж үзүүлэх, дасан зохицож амьдрах</td></tr>
</table>

5.2. Үнэлгээний арга, хэрэгсэл

*Үнэлэх арга:* Өөрийн үнэлгээ, бусдын үнэлгээ, явцын үнэлгээ, үр дүнгийн үнэлгээ

*Үнэлэх хэрэгсэл:* Асуулт, ажиглалт, сэтгэгдэл, санал асуулга, дасгал даалгавар, бичгийн шалгалт, ханын самбар, илтгэл, эсээ, бүтээл зэрэг байна.

## Бага боловсрол

### “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулга хичээл, сургалтын үйл ажиллагааны уялдаа

| Суралцахуйн зорилт | I анги | II анги | III анги | IV анги | V анги |
|---|---|---|---|---|---|
| ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ | | | | | |
| АХУЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ | | | | | |
| *1. Ахуйн осол, гэмтэл* | | | | | |
| а. Хурц ирмэгтэй, үзүүртэй хичээлийн болон ахуйн багаж, хэрэгслийг (хайч, гортиг, шугам, хутга, халуун тогоо, цахилгааны утас, индүү, плитка, зуух, халуун ус, уур гэх мэт) зориулалт, аюулгүй ажиллагааны зааврын дагуу хэрэглэж хэвших | *Бэлтгэл хөтөлбөр (БХ)1.* Хайч, шугам, будаг, харандаа, үзүүртэй зүйлсийг аюулгүй ажиллагааны зааврын дагуу хэрэглэх, осол, аюултай орчинд гэмтэж, бэртэхээс сэргийлэх<br><br>*Хүн ба орчин (ХО)1.* Хичээлийн хэрэглэлээ ялган таних, үүрэг зориулалтаар нь хэрэглэх, хадгалах талаар бусдад ярих; Гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй болгоомжтой харьцах; Гэр, байрны орчин (тухайлбал, гал тогоо) тойронд юу, хаана байдгийг нэрлэх, таних<br><br>*Дүрслэх урлаг технологи (ДУТ)1.* Зурах дүрслэх, бүтээхдээ хэрэглэгдэхүүнийг зөв ашиглах | *Монгол хэл (МХ)2.* Заавар болон асуултыг анхааралтай сонсох, оновчтой хариулах; Үйл ажиллагааны зааврыг ойлгож, дагаж мөрдөх<br><br>*Хүн ба орчин (ХО)2.* Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг юугаар хийгдсэн болохыг судлах, зөв хэрэглэх талаар найздаа зөвлөх<br><br>*Дүрслэх урлаг технологи (ДУТ)2.* Зурах, дүрслэх, бүтээх багаж хэрэглэгдэхүүнийг сонгох, зөв ашиглах; Зурган заавар уншиж ойлгох | *Монгол хэл (МХ)3.* Нэр хаяг , шошго зааврыг уншиж ойлгох; Учир шалтгааны холбоо хамаарлыг илэрхийлэх холбох үг хэрэглэн тайлбарлах /тийм учраас, тэгсэнээс, яагаад гэвэл, ингэснээс болж гэх мэт/<br><br>*Хүн ба орчин (ХО)3.* Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг таних, тэдгээрийг зөв сонгож хэрэглэх, аюулгүй ажиллагааны талаар мэдэх<br><br>*Дүрслэх урлаг технологи (ДУТ)3.* Зурах, дүрслэх, бүтээх багаж хэрэглэгдэхүүнийг сонгох, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлах; Хялбар тоглоомын схем зураглал зааврыг уншиж, ойлгох | *Хүн ба байгаль (ХБ)4.* Металлууд ихэвчлэн цахилгаан сайн дамжуулдаг байхад ихэнх материал яагаад муу дамжуулдагийг турших; Металлыг цахилгааны утас, кабельд хэрэглэдэг, хуванцарыг утас болон залгуур, унтраалгын гэр бүрхүүл болгож хэрэглэдгийн учрыг мэдэх<br><br>*Дүрслэх урлаг технологи (ДУТ)4.* Оёдол эсгүүрийн багаж хэрэгсэл, энгийн гар оёдлоор оёх, товч хадах<br><br>*Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (АЧСУА)4-5.* Гэр бүл, хүний амь, амьдралын үнэ цэнэ | *Монгол хэл (МХ)5.* Энгийн заавар бичих;<br><br>*Дүрслэх урлаг технологи (ДУТ)5.* Жижиг эдлэлийн зохион бүтээлт (эсгэх, оёх) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *Иргэний боловсрол (ИБ)1-5.* Дүрэм журам мөрдөх; Эргэцүүлэн бодох | | | | |
| б. Ахуйн хэрэглээний зүйлсийн нэр, зориулалт, заавар, шошго уншиж ойлгох | *МХ1.* Нэр хаяг унших | *ДУТ2.* Зурган заавар уншиж ойлгох<br>*МХ2.* Үйл ажиллагааны зааврыг ойлгож, дагаж мөрдөх | *МХ3.* Нэр хаяг , шошго зааврыг уншиж ойлгох<br>*ДУТ3.* Хялбар тоглоомын схем зураглал зааврыг уншиж, ойлгох | | |
| | *ИБ1-5.* Эргэцүүлэн бодох | | | | |
| в. Аюул, ослын талаар ойр дотны хүмүүс болон орон нутаг дахь яаралтай тусламжийн утасны дугаар (101, 102, 103, 107)-аас зөвийг сонгон, аюул осол, гэрийн хаяг, байршлыг үнэн зөв мэдээлэл өгөх, тусламж хүсэх | *БХ1.* Тусламж хүсэх үг хэллэг хэрэглэх<br>*МХ1.* Харсан сонссоноо тогтоох, тэмдэглэх, ярих<br>*ХО1.* Гэр бүлийнхнээ танилцуулах, утасны дугаарыг мэдэх, шаардлагатай үед бусадтай холбоо барих; Гэр, сургуулийнхаа болон аймаг, хот, сум, дүүргийнхээ нэр, хаягийг хэлэх, танилцуулах | *ХО2.* Нэн шаардлагатай утасны дугаарыг мэдэж бусдад туслах (101, 102, 103, 109)<br>*МХ2.* Өөрийн болон гэр бүлийн танилцуулга бичих; Бие биедээ асуулт тавьж үндэслэлтэй хариулт өгөх | *ХО3.* Аав, ээж болон гэрийнхэнийхээ мэргэжил, ажлын газрыг мэдэх<br>*МХ3.* Харсан сонссоноо задлан шинжилж, загварчлан тайлбарлах | *МХ4.* Тухайн нөхцөлд дуу хоолой, нүүр царайгаа тохируулан ярих<br>*АЧСҮА4-5.* Гэр бүл, хүний амь, амьдралын үнэ цэнэ | *МХ5.* Үгийн сонголт, дууны өнгөө нөхцөл байдалдаа тохируулан өөрчлөх |
| | *Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (ХГҮА)1-5.* Тэмдэглэлт өдөр ба үйл ажиллагаа<br>*ИБ1-5.* Эргэцүүлэн бодож, шийдвэр гаргах | | | | |
| *2. Эм, ахуйн хэрэглээний бодис, түүний хэрэглээ* | | | | | |
| а. Эм, ахуйн хэрэглээний бодисын нэр, зориулалт, заавар, тэмдэг тэмдэглэгээг уншиж ойлгох<br>б. Эмийн зөв зохистой хэрэглээ, буруу хэрэглэснээс гарах үр дагаврыг ойлгох | *МХ1.* Нэр, хаяг унших | *МХ2.* Үйл ажиллагааны зааврыг ойлгож, дагаж мөрдөх; Үйл явдлыг төсөөлөх<br>*ДУТ2.* Зурган заавар уншиж ойлгох | *МХ3.* Нэр хаяг , шошго зааврыг уншиж ойлгох; Учир шалтгааны холбоо хамаарлыг илэрхийлэх холбох үг хэрэглэн тайлбарлах /тийм учраас, тэгснээс, яагаад гэвэл, ингэснээс болж гэх мэт/ | *МХ4.* Зорилгодоо тохируулан танилцуулга, мэдээ бичих | *МХ5.* Зорилгодоо нийцүүлэн янз бүрийн эх сонгож, харьцуулан унших |
| | *ИБ1-5.* Эргэцүүлэн бодох; Шийдвэр гаргах | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *3. Анхны тусламж* | | | | | |
| а. Яаралтай тусламжийн цүнх, үүргэвч, зориулалтыг мэдэх, бэлтгэх, тайлбарлах<br>б. Ахуйн хүрээний бэртэл, гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн талаар мэддэг байх (шалбарах, эсгэх, түлэгдэх гэх мэт) | | | *МХ3.* Зураг, хүснэгт, графикаас мэдээлэл олж авах | *МХ4.* Сонины мэдээг уншиж хэрэгтэй мэдээллээ тэмдэглэх | |
| | *ХГҮА1-5*: Тэмдэглэлт өдөр ба үйл ажиллагаа | | | | |
| НИЙГМИЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ | | | | | |
| *4. Гэр, сургууль, хүрээлэн буй орчин дахь аюулгүй байдал* | | | | | |
| а. Анги хамт олон, сургуулийн дэг, дүрэм, журмыг мөрдөх, түүнийг мөрдөөгүйгээс гарах үр дагаврыг ойлгох | *БХ1.* Сургуулийн дэгтэй танилцах, ойлгох, анги, хичээлийн дэг зохиоход оролцох, дагаж мөрдөх<br>*ХО1.* Анги хамт олон, сургуулийн орчинд дасан зохицох, сургуулийнхаа дэг журмын талаар мэдлэгтэй болох<br>*МХ1.* Юу бичихээ бодож, жагсаалт гаргах, зурах | *ХО2.* Сургуулийн орчинд баримтлах дэгийг сахиж мөрдөх, хэвшил болгох, хамтран шийдвэр гаргах арга барилд суралцах<br>*МХ2.* Бусдын яриаг анхааралтай сонсох; Бичих санаагаа олох, төлөвлөх, бичих | *ХО3.* Сурагчид дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгааг судлах | *Хүн ба нийгэм (ХН)4.* Гэр бүл, сургуулийн орчинд өөрийн бодол санаа, хүсэлтийг илэрхийлэн харилцах; Гэр бүл, сургууль, ангийн хамт олны амьдралд өөрийн түвшинд оролцох, тэдэнтэй хамтран ажиллах; Хүмүүсийн хамтын амьдралын дэг журмыг мэдэх, сахих; Хувь хүн өөртөө ямар үүрэг, хариуцлага хүлээхийг ойлгох, биелүүлэх, үнэлэх | *Хүн ба нийгэм (ХН)5.* Гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхэн, сургуулийн багш, ажилтан, ахмад хүмүүст өөрийгөө зөв илэрхийлэн харилцах; Гэр бүл, сургууль, ангийн хамт олны амьдралд идэвхтэй оролцох, хамтран ажиллах арга замыг сонгох, түүнийгээ хэрэгжүүлэх;<br>*МХ5.* Үзэл бодлоо хүлээн зөвшөөрүүлэх үндэслэлээ төлөвлөх; Зураг, график ашиглан баримт үзэл бодлыг ялган баримт нотолгоотой бичих |
| | | | | *АЧСҮА4-5*. Гэр бүл, хүний амь, амьдралын үнэ цэнэ | |
| | *ХГҮА1-5*. Сургуулийн үйл ажиллагаа<br>*ИБ1-5*. Эргэцүүлэн бодох; Шийдвэр гаргах | | | | |
| б. Сургууль, гэрийн | *БХ1.* Анги танхим, | *Математик (М)2.* | *Математик (М)3.* | *Хүн ба байгаль (ХБ)4.* | *Математик (М)5.* План |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
